



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

**“Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн
2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот
түвшин болон контрактын биелэлтийн тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Б.Түвшинмөнхтэй байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Б.Түвшинмөнхтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002247